



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,  
ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

БАТЛАВ,  
САЛБАРЫН УЛСЫН  
ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ  
/Албан тушаал/



А.ЭНХМАНЛАЙ  
/Гарын үсгийн тайлал/

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УДИРДАМЖ

2026 оны 02 дугаар сарын 28

Дугаар 35-00/02

Улаанбаатар хот

Урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай

**Нэг. Шалгалтын зорилго, шалгалтын үндэслэл**

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5<sup>3</sup> дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 184 дүгээр "Хяналт шалгалтын 2026 оны төлөвлөгөө батлах тухай" тогтоолд тусгагдсаны дагуу 21 аймгийн 330 сумын 2024-2025 оны газар өмчлөл, эзэмшил, ашиглах эрх олголтын байдал, салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтэд Төрийн хяналт шалгалтын тухай, Газрын тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай, Геодези, зураг зүйн тухай, Хаягжуулалтын тухай, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан норм, норматив, дүрэм, журам, стандартад үнэлгээ дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, цаашид авах арга хэмжээний саналыг тодорхойлж холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэхэд хяналт шалгалтын зорилго оршино.

**Хоёр. Шалгалтад хамрагдах асуудал, хүн, хуулийн этгээд, объектын нэр**

2.1. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад 21 аймгийн 330 суманд 2024-2025 онуудад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар өмчлүүлж, эзэмшүүлж, ашиглуулсан эрх бүхий этгээдийн шийдвэртэй газрууд хамрагдана. Үүнд:

- Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу газар өмчлүүлж, эзэмшүүлж, ашиглуулсан эсэх;

1535080016

- Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасны дагуу дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар олгосон эсэх, дуудлага худалдааны үнийг зөв тогтоосон эсэх, хуульд заасан хэмжээг баримталсан эсэхийг шалгах;

- Газар өмчлөх, эзэмших, ашиглахтай холбогдон гаргасан захирамжийг шүүж Газрын кадастрын цахим систем (egazag.gov.mn)-тай тулгалт хийх;

- Гадаадын иргэн, харьяалалгүй хүн болон хуулийн этгээдэд газар эзэмшүүлж, ашиглуулсан эсэх;

- Газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахад хуулийн этгээдийн хэлбэр, төрөл (гадаадын хөрөнгө оруулалттай байсан эсэх), түүнээс хойш өөрчлөлт орсон эсэх;

- Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн мэдээллийн санд тулгалт хийж, хуулийн этгээд тус бүрийг шалгах;

- Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн “Газрын кадастрын мэдээллийн цахим системд” бүртгэлтэй нэгж талбарын цахим хувийн хэргийг шалгах;

- Шаардлагатай тохиолдолд хэмжилт хийх;

#### **Гурав. Шалгалтын төрөл**

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт.

#### **Дөрөв. Шалгалтын арга**

4.1. Урьдчилан сэргийлэх шалгалтыг Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор батлагдсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам” болон эрх зүйн бусад баримт бичгийн хүрээнд хийж гүйцэтгэнэ.

4.2. Улсын (ахлах) байцаагч нь иргэн, хуулийн этгээдийн хяналт шалгалтад хамрагдах объектын холбогдох баримт бичгийг судалж танилцах, мэдээлэлтэй танилцаж хянан үзэх, тайлбар авах, ажлын байранд үзлэг хийж, баримт бичгийг хуулбарлан баталгаажуулах, шаардлагатай тохиолдолд бараа бүтээгдэхүүн, орчноос дээж авч лабораторийн шинжилгээнд хамруулах, холбогдох төрийн захиргааны байгууллагуудад хадгалагдаж байгаа баримт бичгүүдийг гаргуулж авах, тулгаж үзэх, хувилж авах, хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэн, шалгуулагч этгээдийн хууль тогтоомж, норм, стандартын сахин мөрдөлтийн түвшинг тогтоож, хяналт шалгалтын явцад болон илэрсэн зөрчил, дутагдлыг баримтжуулан фото зураг авах, дүрс бичлэг хийх зэрэг аргуудаар хийж гүйцэтгэнэ.

#### **Тав. Шалгалт хийх бүрэлдэхүүн**

5.1.Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын газар, геодези зураг зүйн улсын (ахлах) байцаагчид болон газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын газар, геодези, зураг зүйн хяналтын улсын (ахлах) байцаагчид батлагдсан төлөвлөгөөний дагуу хамтран хийж гүйцэтгэнэ.

### **Зургаа. Шалгалт эхлэх болон дуусах хугацаа**

Шалгалтыг 2026 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2026 оны 08 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэнэ.

### **Долоо. Шалгалтын дүнг танилцуулах.**

7.1.Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын газар, геодези, зураг зүйн хяналтын улсын (ахлах) байцаагчид урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг удирдамжид заасан хугацаанд хийж гүйцэтгэн, хяналт шалгалтын дүн танилцуулгыг Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор батлагдсан “Хяналт шалгалтын нийтлэг журам”-ын 25 дахь хэсэгт заасны дагуу нэгтгэж тайланг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 2026 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Салбарын хяналт шалгалтын хэлтсийн улсын байцаагч Б.Туулын (tuul.b@gazar.gov.mn) цахим хаягаар загварын дагуу гаргаж ирүүлэх.

7.2.Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын нэгдсэн дүнг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрийг гаргуулж холбогдох газарт хүргүүлж ажиллана.